

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга

1	Эцэг/эхийн нэр: Баяраа Нэр: Рагчаа Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн

Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14^{1.3} дахь хэсэг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 129-132 дугаар зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

1/Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос тус холбооны ерөнхийлөгч **Баяраагийн Рагчааг** нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно.

2/2025.03.20-ны өдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтоолыг баталж, 2025.04.07-ны өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн **Д.Үүрийнтуяаг** томилсон. Сонсголыг зайлшгүй хойшлуулах үндэслэлээр сонсголын товыг 2025.04.22-ны өдөр зохион байгуулахаар дахин товлосон болно.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, dovu.mn, medee.mn, ergelt.mn, dnp.mn сайтад 30 хоногийн хугацаанд давтамжтай байршуулж мөн “Өдрийн сонин”-д зар тавьсан.

-Мэдээллийн дагуу 2 оролцогч нэр дэвшигчээс асуулт асууж, санал хэлэхээр бүртгүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулсан.

-2025.04.08-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8 дахь хэсэгт заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Л.Хоролсүрэнг** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2025.04.17-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

4/2025.04.22-ны өдрийн 10:00 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн **А.Ариунзаяа, Ж.Баярмаа, Ж.Баясгалан, Б.Бейсен, Х.Болормаа, Х.Булгантуяа, Д.Ганмаа, М.Ганхүлэг, С.Зулпхар, Ц.Идэрбат, М.Сарнай, Д.Үүрийнтуяа, Ж.Чинбүрэн, Б.Энхнасан, С.Эрдэнэбат** нарын гишүүд оролцсон.

6/Нэр дэвшигч **Б.Рагчаа** нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч **Л.Хоролсүрэн** дүгнэлтээ танилцуулсан.

7/Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, Ж.Баясгалан, Б.Энхнасан, М.Ганхүлэг, С.Зулпхар, Ж.Чинбүрэн, Б.Булгантуяа, Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа: Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт болон даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ямар бодлого баримтлах талаар;

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат: Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд хэрхэн ил тод, нээлттэй ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв нь даатгалын сантай гэрээт эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээний төлбөрийн гүйцэтгэлтэй уялдахгүй байгаад ямар шийдэл, гаргалгаа байгаа талаар болон хэрхэн үр бүтээлтэй ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхнасан: Эрүүл мэндийн салбарын бодлого боловсруулах чиглэлд нэр дэвшигчийн хийж хэрэгжүүлсэн хамгийн сайн үр дүнд хүрсэн ажлын талаар, нийгмийн эрүүл мэндийн салбарын тогтолцоо ямар байх ёстой талаар, Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлд цаашид юу хийх шаардлагатай талаар болон Үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдвол эхний 6 сард хийх ажлын талаар;

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг: Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг хэрхэн оновчтой бүс, орон нутагт хэрхэн оновчтой хэрэгжүүлэх талаар болон Олон улсын сайн туршлагын талаар;

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар: Эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ямар үр дүн гарсан талаар, шинэ тогтолцоо руу шилжсэнтэй холбогдуулан тулгарч буй сорилт, сорилтыг дагаад үүсч болох эрсдэлийн талаар, одоогийн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүтцийн оновчтой байдал болон бүтцийг оновчтой болгох шийдлийн талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд буюу эрсдэлт өвчлөлийг эрт илрүүлж бага зардлаар эмчлэхэд зарцуулахад анхаарах, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл даатгалын сангийн хөрөнгийг оновчтой зарцуулах шийдвэр гаргах талаар саналаа илэрхийллээ;

Улсын Их Хурлын гишүүн Б.Булгантуяа: Эрүүл мэндийн салбарын менежер, санхүүчийг бэлтгэх, Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн хэрэгжилт болон батлагдсан төсөвт хяналт тавих ажлыг идэвхтэй хэрэгжүүлэхэд анхаарах талаар саналаа илэрхийллээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен: Анхан шатны тусламж үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын талаар, Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг сайжруулах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа: Төрөөс тодорхой хөнгөлөлт үзүүлж байгаа тодорхой бүлгүүдэд чиглэсэн халамжийн даатгалын зардлыг даатгалын сангаас гаргаад явж байна, энэ гажуудлыг засаж даатгалын үндсэн тогтолцоо руу шилжихэд манай улсад ямар хугацаа шаардлагатай талаар, даатгуулагчийн өөрийн хариуцлагыг хэрхэн сайжруулах Үндэсний зөвлөлийн гишүүн болсон тохиолдолд ямар ажил хийхээр төлөвлөж байгаа талаар асуулт асуулаа.

8/Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогч нар дараах дарааллын дагуу нэр дэвшигчээс асуулт асуусан.

Г.Хонгор – Иргэний төлөөлөл

9/Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, оролцогчдийн төлөөллөөс Г.Хонгор нар нэр дэвшигчийг дэмжиж үг хэлсэн.

10/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Д.Үүрийнтуяа хааж үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Д.Үүрийнтуяа: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчийн нээлттэй сонголыг зохион байгууллаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133.1-д заасны дагуу сонсголд оролцсон гишүүд сонсгол явуулснаас хойш 2 өдрийн дотор хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргаж ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж Парламентын цахим хуудаст байршуулах талаар оролцогчдод мэдээлэл өгсөн болно.

3 Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь
Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, **сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих** үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14^{1.3} дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129-132 дугаар зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголыг явуулах үе шатыг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025.04.22-ны өдрийн 10:00 цагт Төрийн ордны Их Эзэн Чингис хаан танхимд зохион байгууллаа.

Сонсголд Нийгмийн бодлогын байнгын хорооны 16 гишүүн, нэр дэвшигч Б.Рагчаа, Хараат бус шинжээч Л.Хоролсүрэн, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Тамгын газрын дарга М.Нармандах, Бодлогын газрын дарга н.Батчимэг, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос Х.Буянжаргал, Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга М.Нямдаваа, иргэдийн төлөөллөөс Г.Хонгор нар оролцлоо.

Улсын Их Хурлын 10 гишүүн, бусад оролцогчдоос 2 иргэн нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131.1 дэх хэсэгт заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2025.04.22-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа.

4 Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд тус холбооны ерөнхийлөгч **Б.Рагчааг** дэвшүүлсэн бөгөөд:

1/Нэр дэвшигч Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилогдвол:

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо даатгуулагчийнхаа эрх ашгийг байж болох түвшинд хамгаалах, болзошгүй эрсдэлээс хамгаалах чадавхыг сайжруулахад анхаарах болно.

Манай улсад ЭМД-ын эв санааны үзэл баримтлалд суурилсан тогтолцоотой бөгөөд цаашид хосолсон шударга тогтолцоотой байх хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал төр хариуцаж байгаа ахмад, хүүхдийн даатгал нь даатгал ачааллаа дийлж чадахгүй байдалд хүргэж байна. Мөн хөрөнгийн удирдлагын байдалд гаргасан алдаануудыг засахад анхаарч ажиллана. Удирдлагын тогтолцоо даатгалын зөвлөл бараг хаалттай байгаа нь асуудал дагуулсаар байна. Тухайлбал гаргасан шийдвэрүүдээ олон нийтэд танилцуулдаггүй, санал зөвлөмж авдаггүй төлөөлөх эрхгүй хүмүүс томилогдсон зэрэг нь дутагдалтай байна. Мөн даатгалын тусламж үйлчилгээний чанар, өртөг, нөхцөл зэрэг бодит үнэлгээ дүгнэлт өгөх шаардлагатай байна. Нөгөө талаар гүйцэтгэлийн санхүүжилтийн хүрээнд үүсэж буй сум, аймаг, дүүрэг, өрхийн эмнэлгүүдийн өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадавх бодит боломжид нийцсэн санхүүжилтүүдийг боловсронгуй болгоход анхаарна. Хүний нөөцийн асуудал нь даатгалын санхүүжилттэй шууд холбогдож байгаа тул давхар тооцож ажиллах шаардлага байна. Үүнээс болж сайн боловсон хүчин хувийн эмнэлэг, төв эмнэлгүүд рүү шилжих бодит эрсдэлүүд нүүрлэж байна. Энэ нь 1,2 -р шатлалын эмнэлгүүдэд бодит хүний нөөцийн эрсдэл илүү нүүрлэж байгаа нь чанар үйлчилгээтэй шууд холбогдож байна. ЭМД-ын үндэсний зөвлөл аливаа шийдвэр гаргахдаа мэргэжлийн экспертүүдийн санал дүгнэлтийг авч гаргаж байх шаардлагатай. Миний бие олон эмч ажилчид даатгуулагчдын санал хүсэлтийг авч ажилладаг тул ЭМДҮЗ-ийн зарим шийдвэрүүд бодит байдалд үл нийцсэн, даатгуулагчдад болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ихээхэн хүндрэл бэрхшээл үзүүлдгийг засаж сайжруулах шаардлагатай.

ЭМД-ын сангийн урьдчилан сэргийлэх уйл ажиллагаанд анхаарах шаардлагатай. ЭМД-ын тогтолцоо үйлчилгээг сайжруулахад даатгуулагчдын эрх ашгийг ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүйгээр үр дүнтэй шийдвэрлэхэд анхаарч үр дүнтэй ажиллахаа илэрхийлэв.

2/Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ:

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 04 сарын 08-ны өдрийн 04 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийг мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий шинээчээр миний бие томилогдсоны дагуу нэр дэвшигч Баяраа овогтой Рагчаагийн бүрдүүлсэн материал болон ярилцлагын үеэр асуусан асуултад хариулсан байдалд үндэслэн шинжээчийн дүгнэлтийг гаргалаа.

Мэдлэгийн талаар: Нэр дэвшигч Б.Рагчаагийн хувьд Хөдөлмөрийн дээд сургуулийг Хөдөлмөрийн эдийн засагч, менежер мэргэжлээр төгсөж тус сургуульдаа Эдийн засгийн ухааны магистрын зэрэг хамгаалсан, Отгонтэнгэр их сургуулийг Эрхзүйч мэргэжлээр тус тус төгссөн эдийн засагч, эрхзүйч хос мэргэжилтэй хүн байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг хууль эрхзүйн хүрээнд үр дүн, үр ашигтай зарцуулах, цаашилбал Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг бүрдүүлэхэд өөрийн хувь нэмэрээ оруулж чадах мэдлэгтэй нэр дэвшигч хэмээн дүгнэж байна.

Мэргэшлийн талаар: Бүрдүүлж ирүүлсэн материал болон ярилцлагын үр дүнгээс харахад нэр дэвшигч эрүүл мэндийн эдийн засаг, бодлого удирдлага, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр мэргэшээгүй байна.

Туршлагын талаар: Нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын үеэр Б.Рагчаа нь эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөц, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замуудын талаар зохих мэдлэг, туршлагатай нь харагдсан. Түүний үйлдвэрчний эвлэлийн холбоодод ажиллаж гишүүдийнхээ эрх ашгийн төлөө ажиллаж байсан туршлага, Албан журмын даатгуулагчдын холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр ажилласан туршлага нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн болбол даатгуулагчдын эрх ашгийн төлөө үр дүнтэй ажиллах суурь болно гэж үзэж байна.

Ур чадварын талаар: Аливаа асуудалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх арга замуудыг боловсруулан оновчтойг сонгох, эдийн засгийн үр дүн, үр ашгийг тооцон хууль эрхзүйн хүрээнд шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэхэд сонирхогч талуудын оролцоог хангах, гэрээ хэлэлцээр хийх зэрэг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд зайлшгүй байх шаардлагатай ур чадварыг эзэмшсэн байна.

Ёс зүйн талаар: Б.Рагчаа нь ашиг сонирхлын зөрчилгүй, ял шийтгэл авч байгаагүй, ёс зүйн хувьд төлөвшсөн хүн хэмээн дүгнэж байна.

Дүгнэлт: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Б.Рагчааг 5 шалгуураар үнэлэхэд мэргэшлийн хувьд шалгуур хангахгүй ч мэдлэг, туршлага, ур чадвар, ёс зүйн хувьд шалгуур хангаж байна.

3/Хаалттай хурлын тайлан

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч **Б.Рагчааг** хараат бус шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд **100 хувийн саналаар дэмжлээ.**

Сонсголд даргалагч:

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ҮҮРИЙНТУЯА